



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/224/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhuyach@audit.gov.mn">enkhuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: <a href="mailto:infoauditselenge@gmail.com">infoauditselenge@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13-14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. Аудитын илрүүлэлт .....	18-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	21-22

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БСШУС</b>	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ТБОНӨХБАУХАТ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**САНТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ӨЛЗИЙБАДРАХ ТАНАА**

2025.02.25 № СЭА-2025/224/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/102 дугаар тушаалын заалтууд болон БШУС-ын 2023 оны А/386 дугаар тушаалын 1.1 дэх заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 15-20.0 хувиар тооцон илүү олгосон,

- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалинг давхардуулан олгосон,
- Батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлээгүй,
- Сургалтын менежерт долоо хоногт заах тогтоосон хэмжээг хэтрүүлэн хичээл заасан гэх үндэслэлээр нэмэгдэл цалин хөлс олгосон,
- Шаардлагагүйгээр их хэмжээний хүнсний материал нөөцөлсөн,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ, ХХОАТ-ын авлага, өр төлбөр үүсгэсэн,
- Гэрээ, төсөв, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримтгүй, албан тушаалтны гарын үсгээр баталгаажаагүй зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан бөгөөд хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ болон цалин, НДШ, ХХОАТ зэрэг ажиллагсадтай хийх тооцоог бүртгэл тайланд зөрүүтэй илэрхийлсэн зэргээр нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сант сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 30,792.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	149,255,980.13	195,084,716.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50,705,978.38	68,297,706.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	50,705,978.38	68,297,706.01
3121	Төгрөг	50,705,978.38	68,297,706.01
31211	Төрийн сангийн харилцах	50,705,978.38	68,297,706.01
33	АВЛАГА		154,130.21
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		154,130.21
35	БАРАА МАТЕРИАЛ	98,550,001.75	126,632,879.99
351	Түүхий эд материал		1,047,197.24
3511	Тусгай зориулалттай материал		1,047,197.24
354	Хангамжийн материал	98,550,001.75	125,585,682.75
3542	Аж ахуйн материал		666,500.00
3546	Хүнсний материал	3,802,400.00	10,803,655.00
3547	Бусад хангамжийн материал	94,747,601.75	114,115,527.75
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,965,902,509.82	4,968,076,238.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,965,902,509.82	4,968,076,238.04
392	Биет хөрөнгө	4,927,174,009.67	4,929,597,737.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,027,748,426.00	5,027,748,426.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(367,558,458.89)	(471,650,107.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,562,500.00	29,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,562,500.00)	(29,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	275,087,342.16	387,450,496.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(158,341,900.01)	(188,470,075.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	167,358,106.15	207,849,126.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(84,653,427.38)	(100,539,518.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,361,159.55	12,361,159.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,136,095.97)	(7,368,276.01)
39217	Ном	61,308,858.06	62,216,507.06
393	Биет бус хөрөнгө	38,728,500.15	38,478,500.19
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,187,499.85)	(1,437,499.81)
39303	Бусад биет бус хөрөнгө	38,416,000.00	38,416,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,115,158,489.95	5,163,160,954.25
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	913,400.00	1,292,572.44
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	913,400.00	1,292,572.44
413	Өглөг	913,400.00	1,292,572.44
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		1,292,572.44
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	913,400.00	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,114,245,089.95	5,161,868,381.81
51	Засгийн газрын хувь оролцоо	5,114,245,089.95	5,161,868,381.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,052,161,520.45	1,052,161,520.45
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,052,161,520.45	1,052,161,520.45
512	Хуримтлагдсан үр дүн	4,062,083,569.50	4,109,706,861.36
5121	Өмнөх үеийн үр дүн	4,062,083,569.50	4,062,083,569.50
5122	Тайлант үеийн үр дүн		47,623,291.86
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,115,158,489.95	5,163,160,954.25

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,416,993,084.56	1,935,806,440.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,122,752,873.87	112,185,886.93
120	Нийтлэг татварын бус орлого	2,122,752,873.87	112,185,886.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,401,768.00	926,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,356,200.00	926,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,045,568.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,102,332,015.47	97,216,363.69
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	17,019,090.40	14,042,723.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,294,240,210.69	1,823,620,553.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,052,094,200.00	1,554,932,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,052,094,200.00	1,554,932,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,600,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,600,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	236,546,010.69	268,688,253.51
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	236,546,010.69	268,688,253.51
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,322,188,729.38	1,888,183,148.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,322,188,729.38	1,888,183,148.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,262,472,614.88	1,836,186,068.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	733,343,714.72	1,168,753,151.77
210101	Үндсэн цалин	524,527,308.58	738,855,594.80
210102	Нэмэгдэл	168,879,895.35	363,853,276.97
210104	Урамшуулал	39,936,510.79	66,044,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,561,183.92	146,226,443.17
210201	Тэтгэврийн даатгал	62,086,572.59	99,444,228.81
210202	Тэтгэмжийн даатгал	7,350,886.80	11,669,182.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,876,112.02	6,382,121.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,467,243.34	5,729,184.33
210205	Эрүүл мэндийн даатгал	14,780,369.17	23,001,725.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	228,653,410.69	261,847,753.51
210301	Гэрэл, цахилгаан	13,351,726.70	17,373,800.00
210302	Түлш, халаалт	212,884,083.99	241,572,753.51
210303	Цэвэр, бохир ус	2,417,600.00	2,901,200.00
2105	Нормативт зардал	54,065,759.20	52,337,570.00
210502	Хоол, хүнс	54,065,759.20	52,337,570.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,492,600.00	2,065,600.00
210604	Урсгал засвар	13,492,600.00	2,065,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,613,500.00	10,857,555.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,386,800.00	2,018,984.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,226,700.00	8,838,571.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,742,446.35	194,097,994.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,265,775.25	34,336,359.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,171,595.40	8,260,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,305,075.70	151,501,635.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,716,114.50	51,997,080.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,716,114.50	51,997,080.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,864,613.80	31,982,280.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,851,500.70	20,014,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,094,804,355.18	47,623,291.86
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,774,491.84	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,774,491.84	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(10,774,491.84)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,084,029,863.34	47,623,291.86

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,297,641,978.69	1,824,547,353.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,401,768.00	926,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,401,768.00	926,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,401,768.00	926,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,356,200.00	926,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,045,568.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,294,240,210.69	1,823,620,553.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,052,094,200.00	1,554,932,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,052,094,200.00	1,554,932,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,600,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,600,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	236,546,010.69	268,688,253.51
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	236,546,010.69	268,688,253.51
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,221,108,056.91	1,750,496,625.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,221,108,056.91	1,750,496,625.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,161,750,756.21	1,697,874,584.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,719,623.33	1,168,104,837.26
210101	Үндсэн цалин	525,903,217.19	711,400,197.65
210102	Нэмэгдэл	168,879,895.35	386,841,659.61
210104	Урамшуулал	39,936,510.79	69,862,980.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,854,483.19	145,736,315.45
210201	Тэтгэврийн даатгал	62,379,871.86	98,351,312.45
210202	Тэтгэмжийн даатгал	7,350,886.80	11,846,103.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,876,112.02	5,923,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,467,243.34	5,923,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,780,369.17	23,692,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	228,653,410.69	260,669,586.74
210301	Гэрэл, цахилгаан	13,351,726.70	17,373,800.00
210302	Түлш, халаалт	212,884,083.99	240,394,586.74
210303	Цэвэр, бохир ус	2,417,600.00	2,901,200.00
2105	Нормативт зардал	52,828,400.00	59,892,030.00
210502	Хоол, хүнс	52,828,400.00	59,892,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,492,600.00	6,840,500.00
210604	Урсгал засвар	13,492,600.00	6,840,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,613,673.00	14,032,555.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,386,800.00	2,018,984.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,226,873.00	12,013,571.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,588,566.00	42,598,759.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,417,666.00	32,923,159.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,170,900.00	9,675,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,357,300.70	52,622,041.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,357,300.70	52,622,041.77
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		1,178,166.77
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,505,800.00	31,429,075.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,851,500.70	20,014,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	76,533,921.78	74,050,727.63
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,083,400.00	56,459,000.00
	Дотоод эх үүсвэрээр	29,083,400.00	56,459,000.00
222001	Тоног төхөөрөмж		51,259,000.00
223001	Бусад хөрөнгө	29,083,400.00	5,200,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(29,083,400.00)	(56,459,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	47,450,521.78	17,591,727.63
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50,705,978.38
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		68,297,706.01

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	1,052,161,520.45		1,977,317,706.16	3,029,479,226.61
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			2,084,029,863.34	2,084,029,863.34
8	2023 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	1,052,161,520.45		4,062,083,569.50	5,114,245,089.95
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			47,623,291.86	47,623,291.86
16	2024 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	1,052,161,520.45		4,109,706,861.36	5,161,868,381.81

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтэрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,875,987,500.00	1,806,955,625.88	69,031,874.12	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,875,987,500.00	1,806,955,625.88	69,031,874.12	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,820,923,100.00	1,754,333,584.11	66,589,515.89	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,210,566,300.00	1,168,104,837.26	42,461,462.74	96.5
210101	Үндсэн цалин	743,445,700.00	711,400,197.65	32,045,502.35	95.7
210102	Нэмэгдэл	405,372,600.00	386,841,659.61	18,530,940.39	95.4
210104	Урамшуулал	61,748,000.00	69,862,980.00	(8,114,980.00)	113.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,320,800.00	145,736,315.45	5,584,484.55	96.3
210201	Тэтгэврийн даатгал	102,898,100.00	98,351,312.45	4,546,787.55	95.6
210202	Тэтгэмжийн даатгал	12,105,700.00	11,846,103.00	259,597.00	97.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,052,800.00	5,923,400.00	129,400.00	97.9
210204	Ажилгүйдлийн даатгал	6,052,800.00	5,923,400.00	129,400.00	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	24,211,400.00	23,692,100.00	519,300.00	97.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,847,800.00	260,669,586.74	1,178,213.26	99.6
210301	Гэрэл, цахилгаан	17,373,800.00	17,373,800.00	-	100.0
210302	Түлш, халаалт	241,572,800.00	240,394,586.74	1,178,213.26	99.5
210303	Цэвэр, бохир ус	2,901,200.00	2,901,200.00	-	100.0
2105	Нормативт зардал	70,344,400.00	59,892,030.00	10,452,370.00	85.1
210502	Хоол, хүнс	70,344,400.00	59,892,030.00	10,452,370.00	85.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	6,840,500.00	1,052,100.00	86.7
210604	Урсгал засвар	7,892,600.00	6,840,500.00	1,052,100.00	86.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,723,300.00	23,552,555.66	170,744.34	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,041,000.00	2,018,984.00	22,016.00	98.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,682,300.00	21,533,571.66	148,728.34	99.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,227,900.00	89,537,759.00	5,690,141.00	94.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,552,300.00	79,862,159.00	5,690,141.00	93.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,675,600.00	9,675,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,064,400.00	52,622,041.77	2,442,358.23	95.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,064,400.00	52,622,041.77	2,442,358.23	95.6
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		1,178,166.77	(1,178,166.77)	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,049,600.00	31,429,075.00	3,620,525.00	89.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,014,800.00	20,014,800.00	-	100.0
222001	Тоног төхөөрөмж		51,259,000.00	(51,259,000.00)	
223001	Бусад хөрөнгө		(51,259,000.00)	51,259,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,875,987,500.00	1,824,547,353.51	51,440,146.49	97.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,606,247,100.00	1,554,932,300.00	51,314,800.00	96.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,554,932,300.00	1,554,932,300.00	-	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	50,687,200.00		50,687,200.00	-
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	269,740,400.00	268,688,253.51	1,052,146.49	99.6
132001	Орон нутгийн төсвөөс	269,740,400.00	268,688,253.51	1,052,146.49	99.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	627,600	926,800.00	(299,200.00)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	627,600	926,800.00	(299,200.00)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50,705,978.38	(50,705,978.38)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		68,297,706.01	(68,297,706.01)	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургууль “Хүсэл тэмүүлэлтэйгээр хамтран суралцдаг, зөв харилцаа хандлагатай, эрүүл зөв дадалтай, бие даасан бүтээлч хүүхэд төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж сурлагын амжилтад ахиц гаргах,
- Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологид суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор” Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;  
Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Сант сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,002.4 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.  
*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	50,706.0	68,297.7	17,591.7
Авлага	-	154.1	154.1
Бараа материал	98,550.0	126,632.9	28,082.9
Үндсэн хөрөнгө	4,965,902.5	4,968,076.2	2,173.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,115,158.5</b>	<b>5,163,160.9</b>	<b>48,002.4</b>
Өр төлбөр	913.4	1,292.6	379.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,114,245.1	5,161,868.3	47,623.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,115,158.5</b>	<b>5,163,160.9</b>	<b>48,002.4</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 68,297.7 мянган төгрөг болж 17,591.7 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 126,632.9 мянган төгрөг болж 28,082.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 128,084.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 229.3 мянган төгрөгийн бөмбөг, Дэлхийн Зөн ОУБ-аас 9,447.2 мянган төгрөгийн дотуур байрны хөнжил, гудас, сургалтын хэрэглэгдэхүүн, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4,366.2 мянган төгрөгийн интернэтийн сүлжээний төхөөрөмжийг хүлээн авч, үйл ажиллагаанд 114,044.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,968,076.2 мянган төгрөг болж 2,173.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 56,459.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн Боловсролын газраас 45,428.6 мянган төгрөгийн зөөврийн компьютер, зурагт, сурах бичиг, хоол үйлдвэрлэлийн хэрэгсэл, Дэлхийн зөн ОУБ-аас 2,373.1 мянган төгрөгийн оёдлын машин, манекан, Дезерет олон улсын байгууллагаас 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 32,012.8 мянган төгрөгийн шүүгээ, самбар, өнгөт принтер, камер, дагалдах хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 151,501.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 1,292.6 мянган төгрөг болж 379.2 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх өр төлбөрийг барагдуулж, тайлант онд шинээр ажиллагсадтай холбоотой НДШ-ийн 1,245.1 мянган төгрөгийн, ХХОАТ-д 47.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэнээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,029,015.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 269,740.4 мянган төгрөг нийт 1,298,756.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 577,231.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,606,247.1 мянган төгрөгөөр, нийт 1,875,987.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,555,559.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 269,740.4 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 50,687.2 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **1,875,987.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 481,728.8 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 8,554.0 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 24,173.7 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 23,723.3 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 39,051.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,606,247.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 269,740.4 мянган төгрөг, нийт 1,875,987.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,806,955.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,806,955.6 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь дотуур байрны зардлыг 29,288.0 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх зардлыг 4,190.4 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 29,397.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт /хувиар/
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>1,606,247.1</b>	<b>1,538,267.4</b>	<b>68,297.7</b>	<b>95.8</b>
80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	2,334.4	2,334.4	-	100.0
80233 - Хүүхэд хамгаалал	2,482.4	1,758.0	724.4	70.8
80312 - Сургалт семинар	1,706.6	1,653.8	52.8	96.9
81605 - Эрүүл мэндийг дэмжих	2,309.4	2,309.4	-	100.0
81801 - Үдийн цай хөтөлбөр	35,049.8	31,429.1	3,620.7	89.7
81806 - Дотуур байр	252,855.1	223,567.1	29,288.0	88.4
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	41,739.0	41,739.0	-	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	6,940.4	2,750.0	4,190.4	39.6
81827 - Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	27,672.0	26,969.7	702.3	97.5
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,130,799.3	1,101,401.5	29,397.8	97.4
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	96,931.5	96,931.5	-	100.0
81848-Сурах бичгийн түрээс	2,340.2	2,019.0	321.2	86.3
81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	3,252.8	3,252.8	-	100.0
83603- Дээд шатны төсвөөс	152.2	152.1	0.1	99.9
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>269,740.4</b>	<b>268,688.2</b>	<b>1,052.2</b>	<b>99.6</b>
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	269,740.4	268,688.2	1,052.2	99.6
<b>ДҮН</b>	<b>1,875,987.5</b>	<b>1,806,955.6</b>	<b>69,349.9</b>	<b>96.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сант сумын ерөнхий боловсролын сургууль хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Дотуур байр хүнс	61,790.4	61,790.4	ХТШ
2	Үдийн цай хүнс	30,890.7	30,890.7	ХТШ
	Нийт дүн	92,681.1	92,681.1	

Уг шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Өглөг баян” ХХК-тай гэрээ байгуулан шууд худалдан авалтыг хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагнахтай холбоотой зөвлөмжийг хүргүүлсэн болно

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,322,188.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,832.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сант сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан

Хоол, хүнсний зардлын хэмнэлтээр 10,803.7 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг байршуулахаас 163 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

Үүнд: Хугацаа хоцроосон

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал - 3 удаа,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт - 3 удаа,
- Санхүүгийн тайлан – 1 удаа,
- Байгууллагын батлагдсан төсөв - 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/59 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 25,494.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 777.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 1,478.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн 2 зөрчилд албан шаардлага, бараа материал дутуу тусгасан, шилэн данстай холбоотой 3 зөрчил илэрч зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 72.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	777.7	1	777.7	100.0
Албан шаардлага	2	1,478.7	1	1,478.7	50.0
Зөвлөмж	3	23,238.3	2	23,238.3	66.6
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>25,494.7</b>	<b>4</b>	<b>25,494.7</b>	<b>72.2</b>

Өмнөх аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч Н.Энхчимэгт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **56,258.6** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,453.9 мянган төгрөгөөр, хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 9,820.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнагдсан,
- ТАЦНС-ээр бодогдсон цалинг санхүүгийн тайлангийн Си Ти Эс программд шууд татуулахгүйгээр гараар оруулахдаа бичилтийг дүн зөрүүтэй буруу хийснээр цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ, ажиллагсадтай хийх тооцооны дансууд зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Үр дүнгийн тайланд боловсролын газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 12,766.2 мянган төгрөгийн бараа материал, 10,306.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу бүртгэсэн, 4,716.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон,
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 14,195.5 мянган төгрөгийн хангамжийн материалыг шууд зардлаар тайлагнасан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **14,037.8** мянган төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрснээс 541.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,496.8 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 7 багшид тус бүр 15-20.0 хувиар тооцон 541.0 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь *“Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно”*, *“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### **5.2 Албан шаардлага**

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 19 багш, ажилтанд 2,594.4 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх *“Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэх

2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 1,245.1 мянган төгрөгийн НДШ-ийн, 47.4 мянган төгрөгийн ХХОАТ өр төлбөр, ажиллагсдаас авах 154.1 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх *“...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ..... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах*

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Н.Энхчимэгт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

3. Хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийн зардлаас 660.0 мянган төгрөгийн мэргэжил дээшлүүлэх сургалтын томилолтын зардлыг санхүүжүүлэн зардлыг зориулалт бусаар зарцуулж гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

4. Зайлшгүй шаардлагаар буюу мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас сургалтын менежерт долоо хоногт заах тогтоосон хэмжээг хэтрүүлэн хичээл заасан гэх үндэслэлээр 445.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, БШУС-ын 2023 оны А/386 дугаар тушаалын 1.1 дэх “*Мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас хичээл, сургалтын тасралтгүй байдал алдагдахад хүрсэн тохиолдолд тухайн сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер болон бусад багш мэргэжилтэй ажилтнаар мэргэжлийн дагуу долоо хоногт 6 хүртэл цагийн хичээл заах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5. Гэрээ, төсөв, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримтгүй, албан тушаалтны гарын үсгээр баталгаажаагүй зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар 8,350.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан бөгөөд хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ болон цалин, НДШ, ХХОАТ зэрэг ажиллагсадтай хийх тооцоог бүртгэл тайланд зөрүүтэй илэрхийлсэн, зэргээр нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7. дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх, нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгө, элэгдэл дутуу илэрхийлэгдсэн	2	14,273.9	2	14,273.9			2	14,273.9				
Журнал бичилтийг буруу хийснээр тайлан бүхэлдээ буруу илэрхийлэгдсэн	1	-			1	-	1	-				
Үнэ төлбөргүй орлого, элэгдлийн зардлыг тусгаагүй орхигдуулсан	3	27,789.2	3	27,789.2			3	27,789.2				
Хангамжийн материалыг шууд зардлаар тайлагнан хасагдуулсан	1	14,195.5			1	14,195.5	1	14,195.5				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>56,258.6</b>	<b>5</b>	<b>42,063.1</b>	<b>2</b>	<b>14,195.5</b>	<b>7</b>	<b>56,258.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж олгоогүй	1	541.0	1	541.0								
Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгэ эс цалинг давхардуулан бодож олгосон	1	2,594.4			1	2,594.4						

Өр төлбөр, авлага үүсгэсэн	1	1,446.6						1	1,446.6		
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	660.0			1	660.0					
Сургалтын менежерийн заах цагийг хэтрүүлсэн	1	445,8			1	445.8					
Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой	1	8,350.0			1	8,350.0					
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>14,037.8</b>	<b>1</b>	<b>541.0</b>	<b>4</b>	<b>12,050.2</b>		<b>1</b>	<b>1,446.6</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим санд 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Шаардлагагүйгээр хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн	1	10,803.7			1	10,803.7		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>10,803.7</b>			<b>1</b>	<b>10,803.7</b>		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>10,803.7</b>			<b>2</b>	<b>10,803.7</b>		